



# ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ “ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН ТАНИЛЦУУЛГА



“ДЦС-2” ТӨХК-ийн Гүйцэтгэх

захирал

Ц.Минжинхүү

Улаанбаатар хотыг цахилгаан, дулааны эрчим хүчээр хангах зорилгоор БНМАУ, БНХАУ-ын Засгийн газар хооронд байгуулсан гэрээний дагуу “Толгойтын дулааны цахилгаан станц”-ыг барьж 1961 оны 12 дугаар сарын 26-ны өдөр 19 цаг 20 минутанд Толгойтын мах комбинат, Тоосгон заводын хэрэглэгчдэд анхны цахилгаан эрчим хүч өгсөнөөр манай компанийн түүхэн замнал эхэлсэн түүхтэй. Улмаар 1965 онд Нийслэлийн 1-р цахилгаан станцтай 35 кВ-ын, 1967 онд Дархан хотын ДЦС-тай 110 кВ-ын цахилгаан дамжуулах хос шугамаар холбогдож төвийн эрчим хүчний систем үүсгэсэн нь өнөөдрийн эрчим хүчний системийн анхдагч суурь болсон. 1968 онд ЗХУ-ын тусламжаар БКЗ-75-39 зуух 2ш, ПТ-12-35/10 турбогенератор тавьж өргөтгөснөөр өнөөдрийг хүртэл хэрэглэгчдийг цахилгаан, дулааны эрчим хүчээр тасралтгүй найдвартай хангасаар ирсэн.

Өнөөдрийн байдлаар тус станц нь жилд дунджаар 160 орчим сая квт.ц цахилгаан эрчим хүч, 230 орчим мянган Гкал дулааны эрчим хүчийг үйлдвэрлэж, цахилгаан эрчим хүчээр 16, технологийн уураар 22, дулаацуулгын дулааны эрчим хүчээр 19 үйлдвэр, аж ахуй нэгжүүдийг шууд ханган ажиллаж байна. “ДЦС-2” ТӨХК-ийн хамт олон жил бүр цахилгаан, дулаан үйлдвэрлэх бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг тогтмол биелүүлэн ажиллаж байгаа бөгөөд 60 жилийн хугацаанд 5,1 тэрбум гаруй кВт.ц цахилгаан эрчим хүч, 11.2 сая Гкал дулааны эрчим хүч түгээсэн эрчим хүчний салбарын ууган үйлдвэр болжээ.

Өнөөдөр тус компани нь 1 алба, 4 хэлтэс, 4 цех, 1 хэсэгтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт 300 гаруй ажилтан ажиллаж байна. Нийт ажилтны 60 гаруй хувь нь дээд болон тусгай дунд боловсролтой байна. Цаашид станцыг мэргэжлийн өндөр чадавхтай боловсон хүчээр хангахад онцгой анхааран их дээд сургууль, коллежуудтай хамтран ажиллаж байна.

Тус станцаас ажил амьдралын гараагаа эхэлсэн Монгол улсын Аж үйлдвэрийн гавъяат ажилтан 6, Монгол улсын төрийн соёрхолт 1 зэрэг алдартнууд төрснөөс гадна Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор 16, Алтан гадас одонгоор 42, Хөдөлмөрийн хүндэт медалиар 55, Засгийн газрын болон салбарын жуух бичгээр 62, Эрчим хүчний болон бусад салбарын цол тэмдгээр 212, Аж үйлдвэрийн тэргүүний мастер цол тэмдгээр 40 хүн тус тус шагнагдсан байна.

## ЭРХЭМ ЗОРИЛГО

**Найдвартай эрчим хүч**

**Шинэ технологи**

**Өөдрөг амьдрал**

## ҮНЭТ ЗҮЙЛ



Зөв менежмент,  
багийн сэтгэлгээ



Эерэг хандлага,  
нийгмийн хариуцлага



Эрүүл,  
аюулгүй орчин



Түүхэн замнал,  
уламжлал



Чадварлаг бүтээлч инженер техникийн  
ажилтан ажиллагсад

## АЛСЫН ХАРАА

Улаанбаатар хотын баруун болон баруун хойд бүсийн үндсэн дулааны эх үүсвэр, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи бүхий цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн төв болно

**"ДЦС-2" ТӨХК****ТҮҮХЭН ЗАМНАЛ****1961**


1961 оны 12 дугаар сарын 26-ны өдөр 19 цаг 20 минутанд залгаж Толгойтын Мах комбинат, Тоосгон заводод анхны цахилгаан гүйдлийг өгчээ.

1964 онд Нийслэлийн 1 дүгээр цахилгаан станцтай 35 кВ –ын, 1967 онд Дархан хотын ДЦС –тай 110 кВ –ын цахилгаан дамжуулах хос шугамаар холбогдож төвийн эрчим хүчний системийн суурийг тавив.

**1964****1969**


1969 онд ЗХУ-ын тусламжаар БКЗ-75-39 ФБ хоёр зуух, ПТ-12-35-10 турбин бүхий өргөтгөлийн хэсгийг ашиглалтанд оруулснаар суурилагдсан хүчин чадал 24 МВт болж нэмэгдсэн.

Зуух №1,3 / ТС-35-39 /-ыг ОХУ-ын Красноярскийн эрчим хүчний институтын эрдэмтэн, инженерүүдийн хамт нүүрсийг усан хөргөлттэй тавцан дээр шатаах дэвшилтэт технологийг нэвтрүүлэв

**2001****2012**

ТС-35-39 зуух №1-ийн үнс барих батерейн циклоныг уутат шүүлтүүрээр сольсноор агаарын бохирдлыг бууруулах үндэсний стандартын шаардлагыг хангах нөхцөл бүрдэв

800м3/ц, 100 м3/ц бүтээмжтэй 90м, 40м напортой сүлжээний хувьсах хурдны насос иж бүрдлийн хамт шинээр суурилуулж, дулааны сүлжээний нэмэлт усны деаэраторын бүтээмжийг 100 тн/ц хүртэл нэмэгдүүлэх ажлыг хийж гүйцэтгэв

**2013****2013**

Турбин №2 /P4 маркийн эсрэг даралтын 4 МВт-ын хүчин чадалтай/-ыг шинэчилж, N-6 маркийн 6 МВт-ын хүчин чадалтай конденсацшлын шинэ турбиныг туслах тоноглолын хамт иж бүрнээр нь суурилууллаа.

БКЗ-75-39ФБ маркийн завсрын бункертэй агаарын хатаалгатай тоос бэлтгэх систем галын хотлын шаталтын процессийг эрчимжсэн буцламтгай давхаргат галын хотол бүхий энерги технологид шилжүүлэх ажлыг амжилттай хийв

**2013****2014**

35 кВ-ын ИХБ, 6 кВ-ын ЕХБ шинэчлэлээр 4 ш таслуур, 10000 кВа-ын ХТ-1ш, 6кв-ын 3 секц бүхий 54 самбараас бүрдэх ХБ иж бүрэн, нум унтраах автомат реактор реле хамгаалалтын хамт бүрэн шинэчлэгдэв

Анх суурьлагдсанаас хойш ашиглаж байсан ПТ-12-35/10 турбины тохируулгын блокыг шинээр иж бүрнээр нь сольсны дүнд турбины эдийн засгийн болон техникийн үзүүлэлтүүд сайжирч, найдвартай ажиллагаа хангагдав.

**2015****2018**

Ротор бутлуур суурилуулах ажлыг амжилттай хийж хэрэгжүүлэв

## ХЭТИЙН ЗОРИЛТ

Улаанбаатар хотын цахилгаан, дулааны эрчим хүчний хэрэглээ жилээс жилд өсч байгаатай уялдуулан тус станц нь суурилагдсан хүчин чадлаа бүрэн ашиглах, үндсэн тоноглолын эвдрэл саатлаас шалтгаалсан зогсолт гаргахгүй байх зорилгыг тавин ажиллаж байна. Энэ зорилгын хүрээнд орчин үеийн дэвшилтэт техник технологи бүхий эрчим хүчний системн оргил ачааллын горимд ажиллах 100 МВт-ын хийн цахилгаан станц, Улаанбаатар хотын дулааны өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах 300 МВт-ын дулааны цахилгаан станцын төслүүдийг боловсруулан Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан техникийн зөвлөлийн хурлаар батлуулж хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.



БНХАУ-ын Эрчим хүчний группийн Тяньжины эрчим хүчний барилга угсралтын компанитай 250-300 мВт-ын техник эдийн засгийн үндэслэл боловсруулах тухай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа.



Эрчим Хүчний Яамны Шинжлэх Ухаан Технологийн Зөвлөлөөр станцын үнсэн сангийн талбайд 300 мВт-ын хүчин чадал бүхий орчин үеийн дулааны цахилгаан станц байгуулах ТЭЗҮ-ийг үндэслэлийг дэмжиж баталлаа.



## ХОЛБОО БАРИХ

Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Дунд гол, 20-р хороо, Утас: 70175169,  
Факс: 70172177, и-мэйл хаяг: [trp2@trp2.energy.mn](mailto:trp2@trp2.energy.mn), Вэб сайт: [www.trp2.mn](http://www.trp2.mn)  
Шуудангийн хаяг: 37-477